

**Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны
хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, 2024 оны эхний 3 сарын байдлаар,
Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), Эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
1	1.1.3. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.	1.Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.	2021-2024	Улсын төсөв	Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдлын үнэлгээ хийгдэж, нөөцийг шинэчилж сэлгэсэн байна.	Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн үед хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахад шаардлагатай эрүүл мэндийн салбарын нөөцийн жагсаалтыг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211 дүгээр тушаалаар батлуулсан.	ЭХГ	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211 дүгээр тушаалаар батлагдсан “Гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн салбарын шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодисын нөөцийн жагсаалт”-ын дагуу 30 эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдалд хяналт үнэлгээ хийхээр төлөвлөгөө гаргасан.
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
2.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.								
2	2.1.8. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	1.Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл, хяналтыг нэвтрүүлнэ	2021-2024	-	Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналт эм хангамжийн байгууллагад бүрэн нэвтэрсэн байна.	Эмийн бүртгэлийн Лайсмед программ хангамжийг Гаалийн ерөнхий газар, Сангийн яамны төлбөрийн баримтын системтэй мэдээлэл солилцуулж байна. Хилээр орж ирж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг гаалийн мэдээллээс иргэдийн гарт очих хүртэлх мэдээлэл солилцож, эмийн үнэ, чанар, аюулгүй байдлын хяналтыг хийхээр 2024 оны 02 дугаар сарын 20-21-ний өдөр уулзалт хийсэн. Энэхүү уулзалтаас гарсан шийдвэрийн дагуу ЭМЯ, ЭЭХХЗГ, Гаалийн	ЛЗЗГ ЭБХ	ЭЭХХЗГ-ын даргын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/45 дугаар тушаалаар ЭМЯ, ЭЭХХЗГ, Гаалийн ерөнхий газар, Гааль, татвар, санхүү мэдээллийн төвийн хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон ажлын хэсгийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Ажлын хэсэг Лайсмед программаар мэдээлэл солилцохтой холбоотой хийх өөрчлөлтийг тодорхойлж, бэлтгэл хийж, алдаанууд засах,

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), Эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						ерөнхий газар, Гааль, татвар, санхүү мэдээллийн төвийн хамтарсан ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна.		гаалийн бүрдүүлэлттэй танилцсан. - Мөн 2 эм импортлогчтой уулзаж, хэрэглэгдэж байгаа програмтай танилцах, гаальтай мэдээлэл солилцох сервис гаргах, программын хөгжүүлэлтийг хийж байна. Ажлын хэсэг нийт 6 удаа уулзалт зохион байгуулсан бөгөөд ГЕГ-ын холбогдох дарга, мэргэжилтнүүдэд 2 удаа, GS-1 байгууллагатай уулзалт зохион байгуулж, бар кодын ашиглалт, хамтран ажиллах чиглэлээ тогтоосон. Мөн мэдээллийн аюулгүй байдлын газраас гааль, татвартай мэдээлэл солилцох сервис гаргахаар хамтран ажиллаж байна. - ГЕГ-аас хамтран ажиллах гэрээний төсөлд ирүүлсэн саналыг тусган хүргүүлсэн. - Эмийг зохистой, аюулгүй хэрэглүүлэх зорилгоор цахим жорын систем нэвтрүүлэх ажилд оролцож, нийт бүртгэлтэй эмийн мэдээлэл, ЭМД-аас хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалт, мансууруулах болон сэтгэц нөлөөт эмийн жагсаалтыг ажлын хэсэгт гарган өгч хөгжүүлэлтэд санал өгч, цахим жорын ач

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), Эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
								холбогдолын талаар мэдээлэл бэлтгэж өгсөн. Эмийн заавар, хайрцаг савлалтын мэдээллийг жор бичүүлсэн иргэнд шууд харагдах, AR технологи ашиглан дуут бичлэгтэй болгохтой холбоотой 100 эмийг сонгон, зааврыг товчлон өгсөн.
3		3.Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлнэ	2022-2024	1,000.0 Улсын төсөв	Арга хэмжээний төлөвлөгөөт үйл ажиллагааны 50 хувь	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/450 дугаар тушаалаар “Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022-2025 онд хэрэгжүүлэхээр баталж, 2024 онд 3 зорилтын хүрээнд 38 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.	ЗУГ	ЭЭХХЗГ-аас 2024 онд “Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний бие даан хэрэгжүүлэх 13 арга хэмжээ, хамтран хэрэгжүүлэх 3 арга хэмжээ тусгагдсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилт хавсралт-1
4		4.Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ	2021-2024	-	Бүх эмнэлэг сүлжээнд нэгдэж, тэсвэржсэн нянгийн мэдээллийг улсын хэмжээнд гаргадаг болсон байна.	2024 оны эхний 2 сарын байдлаар нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэх ажлын хүрээнд WHONET үндэсний сүлжээг өргөжүүлж, 19 аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, 8 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 13 төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, хувийн 15 лаборатори зэрэг нийт 55 эрүүл мэндийн байгууллагад нян судлалын лабораторид WHONET-ийн програм суулгасан. Эрүүл мэндийн байгууллагууд нянгийн тэсвэржилтийн талаарх	ЭАБТСГ	ДЭМБ-ын зөвлөхүүд Монгол улсад ББТ-ийн талаар үндэсний тандалтын тогтолцоог бүрдүүлэх, ББТ-ийн эсрэг эмнэлэгт суурилсан хөтөлбөр хэрэгжилтийн хүрээг боловсруулах чиглэлээр уулзалт зохион байгуулж, агентлагаас ББТ-ийн талаар тулгамдаж буй асуудлын талаар илтгэл тавьж оролцсон.

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), Эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						мэдээллээ өгч хэвшсэн бөгөөд сар бүр дүн шинжилгээ хийх асуудлаар цахим сургалт тогтмол хийгдэж байна.		
5	2.1.8.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	5.Эмийн зохицуулалтын төрийн захиргааны байгууллага байгуулна.	2021-2024	-	Эмийн зохицуулалтын төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа жигдэрсэн байна.	Эрүүл мэндийн яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлөөс яам, агентлагийн хүний нөөцийн бүрдүүлэлтийг хангах зорилгоор салбар зөвлөлийн даргын 2024 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан тусгай шалгалтын комисс нь ЭМЯ, ЗГХА-Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгсэлийн хяналт, зохицуулалтын газрын удирдах, гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. ЗГХА-Эм, эмнэлгийн хэрэгсэлийн хяналт, зохицуулалтын газрын удирдах, гүйцэтгэх 7 албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Шалгалтын дүнд 2 гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо нөхөгдсөн байна.	ЗУГ	Сонгон шалгаруулалтын дагуу ЗГХА-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын удирдах 2, гүйцэтгэх 7 сул орон тооноос 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Нэр дэвшүүлж, санал болгох тухай” 03 дугаар тогтоолоор гүйцэтгэх сул орон тоонд 2 иргэнийг нэр дэвшүүлсэн бөгөөд газар нь 2024 оны 3 дугаар сард Б/48, Б/50 дугаар тушаалаар иргэдийг томилсон.
6		6.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэргүүлэх чиглэлийг үндэслэн эмнэлгийн	2021-2024	-	Эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн дотоодын зах зээлд эзлэх хувь 8 болсон байна.	2023 оны жилийн эцсийн байдлаар эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн дотоодын зах зээлд эзлэх хувь 21.0 байсан. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд эмнэлгийн	ЭҮХ	

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), Эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
		хэрэгслийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ				хэрэгслийг үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг олгоход тухайн үйлдвэрлэлд ашиглах түүхий эд импортлох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг хамт олгох, үйлдвэрлэлд ашиглах түүхий эд, сав, баглаа, боодол, тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжих, инновац шингэсэн үндэсний үйлдвэрийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон алслагдсан бүс нутагт эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэхэд төрөөс хөнгөлөлттэй зээл, татаас олгох зэрэг үйлдвэрлэл дэмжсэн зохицуулалтыг тусгаад байна. Хуулийн төсөлд яамдаас санал авч байгаа бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар 14 яамнаас санал ирүүлсэн. Хуулийн төслийг 2024 оны 03 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.		
7		7.Биобэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ	2021-2024	2,000.0 Улсын төсөв	Биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэл 35 хувиар өссөн байна.	ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЭМУТ зэрэг эрүүл мэндийн байгууллагуудад тэжээлт орчинг тасралтгүй үйлдвэрлэж, тусламж, үйлчилгээнд ашиглаж байна. ЗӨСҮТ-ийн био үйлдвэрлэлийн лаборатори нь нянгийн шалтгаант халдварт	ЭҮХ	

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), Эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						өвчин болох тарваган тахал, боом, холер, хулгана тахал, бруцеллёз, хуурмаг сүрьеэ, листериоз, төрөл бүрийн мөөгөнцөрийн халдварт өвчний оношлогоонд ашиглагдах 33 нэр төрлийн үндсэн, 10 нэр төрлийн хадгалах, тээвэрлэх, 97 нэр төрлийн сонгомол, 188 нэр төрлийн ялган оношлох микробиологийн тэжээлт орчин үйлдвэрлэж байна. НЭМҮТ-д Симмонсын орчин, хатуу шээгийн орчин, шээгтэй шингэн орчин, хатуу, шингэн Сабуро орчин, пептонт ус, тиогликолаттай орчин, мах пептонт агар, мах пептоны шөл тэжээлт орчинг үйлдвэрлэж байна. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг олгоход тухайн үйлдвэрлэлд ашиглах түүхий эд импортлох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ ханган нийлүүлэх тусгай зөвшөөрлийг хамт олгох, үйлдвэрлэлд ашиглах түүхий эд, сав, баглаа, боодол, тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, импортыг орлох, экспортыг дэмжих, инновац шингэсэн үндэсний үйлдвэрийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), Эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						төрөөс хөнгөлөлттэй зээл, татаас олгох зэрэг үйлдвэрлэл дэмжсэн зохицуулалтыг тусгаад байна. Хуулийн төсөлд яамдаас санал авч байгаа бөгөөд 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар 14 яамнаас санал ирүүлсэн. Хуулийн төслийг 2024 оны 03 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.		
8		8. Эмийн аюулгүй байдлын үндэсний лаборатори байгуулна	2024	90.0 Улсын төсөв, гадаадын зээл тусламж	Эмийн аюулгүй байдлын үндэсний лаборатори байгуулах ТЭЗҮ-г боловсруулан батлагдсан байна.	Эмийн аюулгүй байдлын үндэсний лаборатори байгуулах талаар тайлагнаагүй болно.	ЭШЛ	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчлэн найруулж буй төслийн 15 дугаар зүйлийн 15.1-нд Эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний лавлагаа лаборатори гэсэн заалтыг тусгасан.
9		9.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ	2021-2024	500.0 Улсын төсөв	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоотой болно.	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас 2024 онд шалгалт тохируулга хийлгэх хэрэгцээ шаардлагын судалгаа авч, “Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжид 2024 онд шалгалт тохируулга хийх хуваарь”-ийг боловсруулж байна. Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хүрээнд Польш Улсын Storalczyk Mirosław Technologia Pozarnicza	ЭТТГ	L3843/3844/G0672-MON: Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр (1-р үе шат)-ийн 2024 оны ажлын төлөвлөгөөнд “ЭМАШ-ны байгууллагуудад барилга, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний хугацааг сануулах, түүх үүсгэх бүртгэлийн программ хангамж (recall system) боловсруулж, батлуулах, холбогдох сургалтыг зохион байгуулах” ажлыг Эмнэлгийн тоног

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2024 он (сая төгрөг), Эх үүсвэр	2024 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Тайлбар
						компанитай МОН/2021-005-0723 дугаартай гэрээ байгуулсан. Уг гэрээний дагуу 2 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний автомашин (явуулын лаборатори) нийлүүлэгдэнэ. Гэрээний дагуу 2022 оны 06 дугаар сараас автомашины нийлүүлэлт эхлэхээр байсан боловч Украин Улсад болж буй дайны улмаас тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлийн эд ангиудын нийлүүлэлт тасалдаж, гэрээний нийлүүлэлтийн хугацаа хойшилсон. Гэвч нийлүүлэгч талаас эхний ээлжинд гэрээний дагуу нийлүүлэгдэх түргэн тусламжийн 12 автомашиныг ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжуулан ТИР ачааны автомашинд хоёр хоёроор ачиж тээвэрлэлтийг эхлүүлсэн. 2 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний автомашин (явуулын лаборатори) 2024 оны эхний улиралд багтаан нийлүүлэгдэх төлөвлөгөөтэй байна.		төхөөрөмжийн мэдээллийн санд үндэслэн хийхээр тусгагдсан.

2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр